



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 сарын 22 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.3, 9.1.4 дэх заалт нэмсүгэй:

“9.1.3.харьяалах нутаг дэвсгэртээ үйлдвэрлэл, технологийн паркийг барьж байгуулахад дэмжлэг үзүүлэх;

9.1.4.харьяалах нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлаар гарсан шийдвэр, хэрэгжүүлж байгаа төслийн талаар тухай бүрд олон нийтэд мэдээлэх;”

2 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

8.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал паркийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, дэд бүтцийн хөгжил, төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн паркийн нутаг дэвсгэр, байршлыг тогтоох, газрыг тусгай хэрэгцээнд авах;

8.1.2. паркийн үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сан байгуулах, түүнд төсвийн бус хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих;

8.1.3. паркийн дэд бүтцийг барьж байгуулах асуудлыг концесс, үнэт цаас болон бусад хэлбэрээр шийдвэрлэх;

8.1.4. хуульд заасан бусад.”

3 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын дугаарыг “9.1.5” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтын “Тэргүүлэгчдийн” гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР